УВС АЙМГИЙН ТЭС СУМЫН ЕБ-ЫН  СУРГУУЛЬ

# ТЭС  СУМЫН  ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН НЭГДҮГЭЭР СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ СУРАГЧДЫН  ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

**Дугаар: УВ/2025/01/15**

**ТООРОМТ**

## Нэг. **ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

2025.01.15

**Увс аймгийн Тэс сумын Ерөнхий боловсролын сургууль** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос "**ЕБС-ийн дотуур байрны сурагчдын хүнсний материал нийлүүлэх" Багц-1, Багц-2, Багц-3, Багц-4 Багц-5, Багц-6, Багц-7-г** гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг тендерт оролцох иргэд, аж ахуйн нэгж ком-иудаас урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг ***2025 оны 02 сарын 17 -ны өдрийн 10 цаг 00 минут***-аас өмнө **www.tender.gov.mn** хаягаар орж баримт бичгээ байршуулана.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан ***2025 оны 02 сарын 17*** -ны өдрийн ***10 цаг 55 минут*** [1]-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх: **Тооцно**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Увс аймаг, Тэс сум 6-р баг,**

**Тэс сумын ЕБ-ийн сургуулийн ня-бо**

**Ц.Балжинням *утас: 99459669***

[1] тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

| | |
|---|---|
| **1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа** | 1,1 тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх *-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| **2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт** | 2,1Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2,2 Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд ТШӨХ-д засан газар нээлтийг хийнэ. |
| **3. Тендерийн иж бүрдэл** | 3,1 Тендерт орлоцогчийн бэлтгэж ирүүх тендер нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд а Үнийн санал<br>б Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь<br>в Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад<br>г Баримт бичиг<br>д Шаардлагатай тусгай зөвшөөрөл |
| **4. Тогтмол үнэ** | 4,1 тендерт оролцогчийн санал бологосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| **5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд** | 5,1 Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт орлоцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5,2 Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| **6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа** | 6,1 Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| **7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх** | 7,1 Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br>7,2 Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br>7,3 Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |

| | |
|---|---|
| **8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл** | 8,1 Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг / түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт/ тооцсон тендерийн үнэ байна. |

## Гурав.**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

| **ТӨЗ-ны холбогдох заалт** | **А. Ерөнхий зүйл** |
|---|---|
| **ТӨЗ 1.1(а)** | Захиалагч нь:Увс аймгийн Тэс сумын ЕБ-ын сургуулийн байр |
| **ТӨЗ 1.1(б)** | Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: *Тэс сумын ЕБ-ын нэгдүгээр сургуулийн **ДБ-ны хүүхдийн хоолны материал** нийлүүлэх гүйцэтгэгч сонгох* |
| **ТӨЗ 1.1(в)** | Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:<br>4 багцаас бүрдэнэ. Үүнд:<br>Багц-1: **Гурил, гурилан бүтээгдэхүүн**<br>Багц-2: **Сүү, сүүн бүтээгдэхүүн**<br>Багц-3: **Мах, махан бүээгдэхүүн**<br>Багц-4: **Жимс,жимсгэнэ**<br>Багц-5: **Төмс хүнсний ногоо**<br>Багц-6: **Будаа**<br>Багц-7: **Бусад хүнсний бүээгдэхүүн** |
| **ТӨЗ 1.1(г)** | Санхүүжилтийн эх үүсвэр нь: *Улсын төсвийн урсгал зардал*<br>*Нийт баталсан төсөв-**664.859.200** төгрөг*<br>*2025 оны санхүүжилтийн дүн-**664.859.200** төгрөг*<br>Багц-1: Гурил, гурилан бүтээгдэхүүн**-119.080.000**<br>Багц-2: Сүү, сүүн бүтээгдэхүүн **-55.500.000**<br>Багц-3: Мах, махан бүээгдэхүүн **-280.000.000**<br>**Багц-4:** Жимс,жимсгэнэ**-85.800.000**<br>Багц-5: Төмс хүнсний ногоо**-61.270.000**<br>Багц-6: Будаа **-43.600.000**<br>Багц-7: Бусад хүнсний бүээгдэхүүн **-19.609.200** |
| **ТӨЗ 1.1(д)** | Тендерт оролцогч нь ТӨЗ-ийн 4.2.1-4.2.9-д дурьдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж, эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу холбогдох баримт, нотолгоог тендерт хавсарган захиалагчид иргүүлнэ. |

| Б. Тендерийн баримт бичиг | |
|---|---|
| **ТӨЗ 1.1(е)** | Тендерт оролцогч тендерийн баримт, бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх шаардлагатай бөгөөд тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлээгүй байх, маягтыг дутуу бөглөж ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. |
| **ТӨЗ 1.1(ё)** | Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг:<br>Тодоруулгыг http://www.tender.gov.mn сайтаар дамжуулан оролцогчид өгнө. |
| **ТӨЗ 1.1(ж)** | Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын ***5*** **хоногоос багагүй байна.** |
| **В. Тендер бэлтгэх** | |
| **ТӨЗ 3.1(а)** | Тендерийн хэл нь **Монгол хэл** байна. |
| **ТӨЗ 3.1(б)** | Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг дор дурьдсан хэсэг, бүлэгт заасан дараалалд нийцсэн иж бүрдэл баримт бичиг болгон бэлтгэх буюу шаардлагатай бол ТӨЗ-д заасны дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтийг тусгасан байна. Үүнд:<br>I. ХЭСЭГ<br>Бүлэг 1.Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу бэлтгэсэн баримт бичиг, нотлох баримт<br>Бүлэг 2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт, түүнд заасан баримт бичиг, нотлох баримт<br>Бүлэг 3. Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуурт хамаарах дараах баримт бичгийг ирүүлэх. Үүнд:<br>-ТӨЗ-ны 3.1-д заасан нэмэлт материал,<br>-тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай нотлох баримт<br>-Тендерт оролцогчийг төлөөлж тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл<br>-тендерт оролцогчийг тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай нотлох баримтууд<br>Бүлэг 4. Тендер шалгаруулалтын үнэлгээнд хамаарах дараах баримтыг тендерийн багц тус бүрд ирүүлэх.Үүнд:<br>-Тендерийн маягт<br>-Үнийн санал, хуваарь<br>-дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн нэр, өртөгийг дотоод валютаар илэрхийлж ирүүлнэ<br>II. ХЭСЭГ<br>Бүлэг 5. Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлага болон техникийн тодорхойлолтыг хангах талаар тендерт оролцогчийн санал, нотлох баримтыг тендерийн багц тус бүрээр гаргах. Үүнд:<br>-Санал болгосон бараа нь захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолт болон стандартад нийцэхийг зүйл заалт нэг бүрээр |

| | |
|---|---|
| | нотлон харуулсан тайлбар,нотлох баримтыг бэлтгэж ирүүлэх ба нотлох баримтыг нийтлэл, зураг, өгөгдөл, орц норм, үйлдвэрлэгчийн тогтоолгосон стандарт, итгэмжлэгдсэн лаборатороор шинжилгээ хийлгэсэн тухай шинжилгээний баримт бичиг, барааны тэмдэг, холбогдох хэдэн үйлдвэрлэгч, борлуулагчийн онлайн хаягаас татаж харьцуулж болох талаарх зөвлөмж хэлбэрүүдтэй байж болно.<br>–Тендерт өөр стандарт барааны катлогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн тодорхойлолтод заасантай дүйцэхүүц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна.<br>-барааны техникийн тодорхойлолт, ашиглалтын заавар, барааны гарал үүсэл, чанарын сертификат, үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн зөвшөөрөлийг ирүүлнэ.<br>III. ХЭСЭГ<br>Бүлэг 6. Гэрээний ерөнхий, тусгай нөхцөлийг зөвшөөрөх эсэх санал, шийдвэрийг багц тус бүрд ирүүлэх<br>Бүлэг 7. Гүйцэтгэлийн баталгаа шаардсан тохиолдолд ирүүлэх эсэх саналыг саналыг багц тус бүрд ирүүлэх /уг тендерт шаардлагагүй/<br>Бүлэг 8. Урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилт авах эсэх талаарх санал /уг тендерт шаардлагагүй/ |

| | |
|---|---|
| **ТӨӨЗ 3.1 (в)** | Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд: **Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйл буюу тендерт оролцогч гэрээ хэрэгжүүлэх чадвартайгаа нотолж тендерт ирүүлэх чадварын мэдээллүүд: Үүнд:**<br>1. Сүүлийн 2 жил буюу 2023, 2024 онд санал болгосон үнийн дүнгийн 100 хувиас дээш хэмжээний борлуулалтын орлоготой байсныг нотлох баримт бичиг /санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт/ ирүүлнэ.<br>2. Сүүлийн 2 жил 2023,2024 онд хүнсний бүтээгдэхүүн, мах махан болон сүү сүүн бүтээгдэхүүн, хүнсний өргөн хэрэглээний материал нийлүүлсэн ажлыг гэрээгээр гүйцэтгэж байсан туршлагатай байх.<br>3.Татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын тодорхойлолтууд ирүүлнэ. Тодорхойлолтууд нь гаргаснаас хойш 1 сарын дотор хүчинтэй байна. Татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно. Татвар, нийгмийн даатгал бусад байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөртэй, сүүлийн 3 жилд ял шийтгэлтэй, одоо өр төлбөртэй байсан нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.<br>4. Тендерт оролцогч олон багцтай тендерт оролцох болон хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл, тус гэрээнд ажиллаж байгаа, ажиллуулах голлох инженер, техникийн ажилтан, ажилчид, машин механизм, багаж хэрэгсэл, |

агуулахыг танилцуулах бөгөөд тэдгээр нь санал болгож буй тендерийн саналтай давхардсан тохиолдолд болон уг мэдээллийг ирүүлээгүй эсвэл худал мэдүүлсэн нөхцөлд оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно. Хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эрх авсан гэрээний хугацаа, өртөг, захиалагчийн албан ѐсны хаяг, байршил, харилцах утасны дугаарын талаарх мэдээллийг ирүүлнэ.

5. Тендерт оролцогчийн санал болгосон нийт инженер техникийн ажилтан, ажилчид нь өөрийн компанийн үндсэн ажилтан байх ба тэдгээр ажилтнуудын НДШ-ийг тендерт оролцогч өөрөө төлсөн болохыг НД-ын байгууллагын НД№7, НД№8 маягтаар гаргасан тодорхойлолт лавлагаа, ажилтны нийгмийн даатгалын дэвтэрийн нотариатоор батлуулсан хуулбарыг тус тус үндэслэн тогтооно. Тухайн барааг нийлүүлэхэд шаардлагатай инженер техникийн ажилтнууд, мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн бэлтгэл, туршлагыг захиалагчаас тогтоосноор дараах хүснэгтээр ирүүлнэ. Үүнд:

Албан Мэргэжил, Хүний Мэргэжлээрээ НД-ийн тушаал боловсрол
тоо ажилласан жилийн дэвтрийн
тоо дугаар

| | | | | |
|---|---|---|---|---|
| Менежер | Худалдааны мэргэжилтэн | 1 | 2-оос жил | |
| Жолооч | Жолооч | 1 | 2-оос | |
| | | | | |

*Энэ хүснэгтэд заасан ИТА, мэргэжилтэй ажилчдын иргэний үнэмлэх, диплом, мэргэжлийн үнэмлэх зэрэг баримт бичгийн эх хувиас татсан хуулбарыг тендерт ирүүлнэ*

6. Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас татсан хуулбарыг нотариатаар батлуулж ирүүлнэ.

7. Хүнсний материал худалдах, борлуулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ.

8. Аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг хавсралт №1-ээр гаргаж ирүүлнэ

9. Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн нөхцөл бүхий тендер ирүүлсэн оролцогчийн тендерээс татгалзана.

10. Ажлын байрны дүгнэлтийн хуулбар

11. Санал болгож буй барааны нийлүүлэлтийн хуваарийг боловсруулж тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж тендерт ирүүлнэ. Ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.

12. Санал болгож буй санхүүжилтийн хуваарийг боловсруулж тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж тендерт

| | |
|---|---|
| | ирүүлнэ<br>13. Зайлшгүй өгөх шинжилгээнд хамрагдаж эрүүл мэндийн цагаан дэвтэр таглуулсан байна.<br><br>Дээрхи нэмэлт материалуудаас нэг буюу хэд хэдэн баримт бичиг нотлох баримт ирүүлээгүй, эсвэл шаардлага хангахааргүй, баталгаажилтгүй ба зөрчил бүхий хуурамч нотлох баримтууд ирүүлсэн, сүүлийн **3** жилд нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний чанар хангалтгүй байсан нь өмнөх захиалагч байгууллагуудын тодорхойлолтоор болон хяналт шалгалтын байгууллагын дүгнэлтээр нотлогдсон зэрэг тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. |
| **ТОӨЗ 3.1(г)** | Хувилбарт тендер ирүүлэхийг ***"зөвшөөрөхгүй"*** |
| **ТОӨЗ 3.1(д)** | Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс -ийн хувилбар:<br>***"Incoterms 2000*** |
| **ТОӨЗ 3.1(е)** | Бараа хүргэгдэх газар: ***Увс аймгийн Тэс сумын ЕБ-ын сургууль*** |
| **ТОӨЗ 3.1(ё)** | "Бараа хүргэгдэх эцсийн цэг (Захиалагчийн агуулах, эсхүл барааг эцсийн хэрэглэгчид хүргэх байршил)": ***Увс аймгийн Тэс сумын ЕБ-ын сургуулийн хүнсний агуулах*** |
| **ТОӨЗ 3.1(ж)** | Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад ***"тохируулахгүй" Гэрээний үнэ тогтмол***<br><br>*Хэрэв гэрээний үнийг тохируулах бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг захиалагч тендер зарлахаас өмнө урьдчилан тогтоож, 7 дугаар бүлэгт заасан гэрээний нөхцөлд тусгана.* |
| **ТОӨЗ 3.1(з)** | Тендерийн валют: ***Төгрөг байна.*** |
| **ТОӨЗ 3.1(и)** | Үйлдвэрлэгч, борлуулагчийн зөвшөөрөл: ***"шаардлагатай"***<br>***Үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн зөвшөөрөл, лабораторийн шинжилгээ, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг тус тус ирүүлнэ.*** |
| **ТОӨЗ 3.1(й)** | Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: ***2023,2024 оны*** **санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх бөгөөд тайлан ирүүлсэн жилд ашигтай ажилласан байна.** |
| **ТОӨЗ 3.1 (к)** | Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2 жил /2023, 2024/<br>**Сүүлийн 2 жилд төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжид хүнсний бүтээгдэхүүн нийлүүлж байсан гэрээ, гэрээний нэрэгжилтийн мэдээллийг дараах хүснэгтээр ирүүлнэ:** |

| № | Гэрээний | Бараан | Гэрээний | Захиалагчийн мэдээлэл |
|---|---|---|---|---|

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | нэр | ы нэр | үнэ | Нэр | Хаяг | Утасны дугаар |
| | | | | | | |

**Дээрх мэдээллийн хамт өмнөх захиалагч байгууллагуудтай сүүлийн 2**
**жилд байгуулсан гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт, гэрээний хэрэгжилтийн үр дүнгийн талаар өмнөх бүх захиалагчийн**

| | |
|---|---|
| | **тодорхойлолтыг ирүүлнэ.** |
| **ТӨЗ 3.1(л)** | Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: ***Чанаргүй бараа нийлүүлсэн тохиолдолд шинэ бараагаар солих, захиалагчид учирсан хохиролыг нөхөн төлнө. Нийлүүлсэнээс хойшхи хадгалалт, хамгаалалтаас шалтгаалсан аливаа чанар аюулгүй байдалтай холбоотой асуудлыг захиалагч хариуцна.*** |
| **ТӨЗ 3.1(м)** | Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2023, 2024 онд төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжид гэрээгээр хүнсний бүтээгдэхүүн нийлүүлж байсан туршлагатай байна. |
| **ТӨЗ 3.1(н)** | Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо***: заахгүй*** |
| **ТӨЗ 3.1 (о)** | Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: *Гэрээт ажилд ашиглах дурьдсан машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн үзүүлэлт, жагсаалтыг доорх хүснэгтэд зааснаар бэлтгэж, тэдгээрийн гэрчилгээний эхээс татсан хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ /машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь компанийн өөрийн эзэмшлийнх эсхүл түрээсийнх байж болох бөгөөд 2024 оны түрээсийн гэрээний эх хувийг ирүүлнэ/ Үүнд:* |

| *Машин тоног, төхөөрөмж, техник хэрэгслийн нэр, зориулалт* | *Тоо ширхэг* | *Улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаар* | *Эзэмшигч* | *Чанар байдал ашиглалтад орсон огноо* |
|---|---|---|---|---|
| *Хүнсний бүтээгдхүүн тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэл* | | | | |

| | |
|---|---|
| **ТӨЗ 3.1(ө)** | Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: *Төсөвт өртгийн 30%-иас багагүй байх*<br>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно.<br>*-Арилжааны банкнаас зээл олгох бололцоотой болохыг нотлох тодорхойлолт* |
| **ТӨЗ 3.1(п)** | Ашигтай ажилласан байх жилийн тоо: *2023,2024 онд ашигтай ажилласан байна.* |

| | |
|---|---|
| **ТӨЗ 3.1(р)** | Тендерт оролцогчийн санал болгосон бараа нь захиалагчаас шаардсан тухайн барааны тодорхойлолт /стандарт/-ын үзүүлэлт, нөхцөл тус бүрийг хангаж буйг харуулах техникийн тодорхойлолт, тайлбар нотлохыг баримтыг бэлтгэж тендерт ирүүлнэ |
| **ТӨЗ 6.1** | Тендер нээснээс хойш ***30*** хоногийн туршид хүчинтэй байна. |
| **ТӨЗ 7.1(а)** | Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: **цахим системээр ирүүлэх тохиолдолд хувь заахгүй** |
| **Г. Тендер ирүүлэх** | |
| **ТӨЗ 7.1(б)** | Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь:<br>Тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж **50000**<br>/тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны маркетенгийн системийг ашиглан төлнө.<br>төрийн сан банкны 100151515160 дансанд шилжүүлнэ.<br>Байгууллагын хаяг: Увс аймгийн Тэс сумын ЕБС<br>Аймаг, хот: **Увс аймаг Тэс сум,**<br>Улс: **Монгол Улс** |
| **ТӨЗ 7.1(в)** | Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: Увс аймгийн Тэс сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн Дотуур байрны хоолны материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох |
| | Тендерт оролцогч нь тендерийн дугаар бүрийг дугаарлаж, гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Тендерийн эхний нүүрэнд тендерийн товъёог хөтөлж оруулна. |
| **ТӨЗ 7.1 (г)** | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:<br>Огноо: 2025 оны 02 дугээр сарын 17-ны өдөр<br>Цаг: 10 цаг 00 минут |
| **Д. Тендерийг нээх, үнэлэх** | |
| **ТӨЗ 7.1(д)** | Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:<br>Байшин, гудамжны нэр: Увс аймгийн Тэс сумын ЕБ-ын сургууль нягтлангийн өрөө<br>Аймаг, хот: Увс аймаг Тэс сум,<br>Улс: Монгол Улс |

| | |
|---|---|
| | Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:<br>Огноо: 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Цаг: 11 цаг 30 минут |
| **ТОӨЗ 7.1(е)** | Томоохон зөрүү тооцоогүй бага хэмжээний орхигдуулсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг тооцон мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэд залруулга хийх,<br>-Тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тусгах Арифметик алдааг тооцож тендерийн үнийг залруулах |
| **ТОӨЗ 8.1** | Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: ***0 хувь***<br>Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: ***0 хувь*** |
| **ТӨОЗ 8.1(а)** | Гэрээ байгуулах эрх олгосон тухай болон тендерт шалгараагүй оролцогчийн мэйл хаягаар илгээх тул тендерт оролцогч тендерт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг энд заасан мэдээллийн хэрэгслээс үзэж мэдээлэл авах үүрэгтэй. Мэдэгдлийн эх хувийг бичгээр илгээнэ Гэрээ байгуулах эрх олгох |

. Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ ХҮҮХДИЙН ХООЛНЫ ХҮНСНИЙ МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## А. НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1. **Барааны тодорхойлолт:**

- Сургуулийн дотуур байрны хүүхдийн хүнсний материал нийлүүлэх бүтээгдэхүүн хүнсний аюулгүй байдлыг хангасан байх.
- Нийлүүлэлтийг нярвын захиалгын дагуу тухай бүр нь хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолтын дагуу үнийн саналыг ирүүлэх ба заасан нэр төрлөөс өөр бүтээгдэхүүн нийлүүлэхгүй байх.
- Бараа бүтээгдэхүүн тус бүр мэргэжлийн хяналтын зөвшөөрөлтэй бараа байх шаардлагатай.
- Мах сүү нь нийлүүлэлт бүрт шинжилгээний бичигтэй байх.
- Үйлдвэрлэгдсэн улс нь тодорхой байх, барааг дагалдах бичиг баримттай байна.

2. **Стандарт:**

- Монгол улсын хүнсний стандарт болон олон улсын стандартыг хангасан байна.
- Мах, сүү болон бусад шаардлагатай бүтээгдэхүүнийг нийлүүлэлт бүрт шинжилгээний бичиг ирүүлэх шаардлагатай.

3. **Баглаа, боодол:** • Бараа бүрийн онцлогоос хамаарч сав баглаа боодолтой

байна.

- Сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй байх шаардлагатай.
- Сав баглаа боодлын шошго, хаяг, нэр нь тод бүрэн байх.
- Зориулалтын сав баглаа боодолтой байх.
- Сүү, шүүсийг төмөр саванд савлаж авчирна.
- Махыг ариун цэврийн шаардлага хангасан сав баглаа боодолд савлаж нийлүүлнэ.

4 **Бараа хүргэх газар:** ЕБС-ийн складанд

## Б. ТУСГАЙ ШААРДЛАГА

**Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны сурагчдын хоол, хүнсний бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт.**

| Бараа болон холбогдох үйлчилгээний нэр | Таних тэмдэг, нэр томъёо | Техникийн тодорхойлолт болон мөрдөх стандарт |
|---|---|---|
| Үхрийн мах | I зэрэглэл | I зэргийн, гарал үүсэл, шинжилгээний бичигтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан, стандартад нийцсэн, илчлэг сайтай байх. Эцэг малын мах хорих, мах бэлтгэл маш цэвэр стандартын шаардлага хангасан, жижиглэсэн, өнгө зүс сайтай, өөх мах алагласан байх. |
| Хонины мах | I зэрэглэл | |
| Улаан буудайн гурил | I зэрэг MNS 0244 – 2009 8 х | I зэргийн гарал үүсэл, шинжилгээний бичигтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан, стандартад нийцсэн байх, илчлэг сайтай, орон нутгийн дээд зэргийн цавуулагтай, хөөлт сайн, орон нутагтаа тарьж ургуулсан. |
| Төмс | Монгол | Орон нутгийн хөрсөнд тарьж ургуулсан, шинжилгээгээр хянуулсан, баталгаатай, эрүүл ахуйн шаардлага хангасан, стандартад нийцсэн байх, хадгалалтын горимд нийцсэн, ялзраагүй, хөлдөөгүй, чийглэгийн хэмжээ сайн, хатаж хорчийгоогүй, төмс нь шороо багатай. |
| Байцай | | |
| Лууван | | |
| Сонгино | | |
| Манжин | | |
| Сармис | | |
| Цагаан будаа | MNS 041- 1961 2 х | Шинжилгээний бичигтэй, сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, Солонгос, Орос улсад үйлдвэрлэсэн. |
| Үзэм | MNS 041- 1961 2 х | Шинжилгээний бичигтэй, сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, Орос улсад үйлдвэрлэсэн. Чийглэгтэй, чулуугүй, цэвэрхэн. |
| Лапша гоймон | MNS 142 - 85 | Шинжилгээний бичигтэй, сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, Орос, Монгол улсад үйлдвэрлэсэн, илчлэг сайтай. |
| Мушгиа | | |
| Варень | | Шинжилгээний бичигтэй, сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, Орос, Монгол улсад үйлдвэрлэсэн, илчлэг сайтай. |
| Масло | MNS CAC 23.99 | Шинжилгээний бичигтэй, сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, Орос, Монгол улсад үйлдвэрлэсэн, кг-аар савласан. |
| Хөц будаа | MNS 4515 – 1997 4х | Шинжилгээний бичигтэй, сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, Орос, Монгол улсад үйлдвэрлэсэн, орон нутгийн хөрсөнд тарьж ургуулсан, илчлэг сайтай. |
| Гурвалжин будаа | MNS 4515 – 1997 4х | Шинжилгээний бичигтэй, сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, Орос, Монгол улсад үйлдвэрлэсэн, орон нутгийн хөрсөнд тарьж ургуулсан, илчлэг сайтай. |

| | | |
|---|---|---|
| Хүү будаа \каш\ | MNS 0243 2003 | Шинжилгээний бичигтэй, сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, Орос, Монгол улсад үйлдвэрлэсэн |
| Хуурай шахмал цай | | Шинжилгээний бичигтэй, сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, Орос, Монгол улсад үйлдвэрлэсэн. |
| Гурилан боов | | Орон нутагтаа үйлдвэрлэсэн, хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрийн бүтээгдэхүүн. |
| Нарийн гоймон | MNS 142 – 85 | Шинжилгээний бичигтэй, сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, “Алтан тариа” ХХК-ны илчлэг сайтай. |
| Сүү<br>Сүү \Савлаж ууталсан\ | MNS ISO 9001 - 2010 | Малын шинэ боловсруулаагүй, тослог ихтэй шингэн сүү, шинжилгээний бичигтэй, гарал үүслийн бичиг эзнийг тодорхой бичих, 7 хоногийн 4 өдөр нийлүүлэх. Сав баглаа боодолтой. Хүүхдийн нас биений онцлогт тохирсон. Стандартад нийцсэн байх. |
| Шар будаа | MNS 05 33: 1998 | Шинжилгээний бичигтэй, сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, Орос, Монгол улсад үйлдвэрлэсэн |
| Ургамлын тос | | Шинжилгээний бичигтэй,стандарт эрүүл ахуйд нийцсэн, шошготой, Орос, Солонгос улсад үйлдвэрлэсэн |
| Цөцгийн тос | MNS CAC 23.99 | Шинжилгээний бичигтэй, сав баглаа боодол нь стандартад нийцсэн, шошготой, Орос, Монгол улсад үйлдвэрлэсэн, кг-аар |
| Аарц | | Шинжилгээний бичигтэй, шар сүү багатай, эзнийг нь тодорхой бичих. |
| Элсэн чихэр | | Шинжилгээний бичигтэй,стандарт эрүүл ахуйд нийцсэн, шошготой, Орос, Солонгос улсад үйлдвэрлэсэн |

## В. НИЙЛҮҮЛЭХ БАРААНЫ НЭР , ХЭМЖЭЭ, ҮНЭ

### Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

*[ огноо]*

***(Захиалагч байгууллагын нэр)***-ын дарга __________________ танаа

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр]* дор дурдсан барааг ***[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу ***[тоо]*** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлол т | Барааны гарал үүслийн | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

Баталгаат засварын хугацаа:
Санал болгож буй бусад нөхцөл:
Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:
Албан тушаал, нэр: Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|---|---|---|---|---|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Дотуур байрны хүүхдийн хоолны захиалга2025 он

| № | | Бүтээгдэхүүний нэр | хэмжих хэгж | материалын хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | | Гурил,гурилан бүтээгдэхүүн | | |
| | 1 | Гурил | кг | 4000 |
| | 2 | Лавшаа | кг | 2500 |
| | 3 | Орос гоймон | кг | 2500 |
| | 4 | Бүхэл үрийн гурил | кг | 500 |
| | 5 | Каш | кг | 400 |
| | 6 | Талх /Цагаан/ | кг | 8000 |
| | 7 | Талх /хар/ | кг | 5000 |
| | 8 | Талх/Хөх тариа/ | кг | 5000 |
| | 9 | Арвайн гурилтай жигнэмэг | кг | 500 |
| | 10 | Овьёостой жигнэмэг | кг | 500 |
| | 11 | Боорцог үзэмтэй | кг | 2000 |
| | 12 | Аарцны шанзтай хомбоо | кг | 2000 |
| | 13 | Боорцог/Зүсмэл/ | кг | 2000 |
| | | | | |
| 2 | | Сүү,сүүн бүтээгдэхүүн | | |
| | 1 | Сүү | кг | 5000 |
| | 2 | Тараг | кг | 3000 |
| | 3 | Аарц | кг | 600 |
| | 4 | Өрөм | кг | 500 |
| | 5 | Зөөхий | кг | 500 |
| | | | | |
| 3 | | Мах,махан бүтээгдэхүүн | | |
| | 1 | Үхэр | кг | 15000 |
| | 2 | Хонь | кг | 10000 |
| | | | | |
| 4 | | Жимс,жимсгэнэ | | |
| | 1 | Үхрийн нүдний шүүс | кг | 700 |
| | 2 | Чацарганы шүүс | кг | 700 |
| | 3 | аньсны шүүс | кг | 700 |
| | 4 | Үхрийн нүдны чанамал | кг | 500 |
| | 5 | Алим | кг | 800 |
| | 6 | Мандирин | кг | 800 |
| | 7 | Усан үзэм | кг | 800 |
| | 8 | Гадил | кг | 500 |
| | 9 | Нэрс | кг | 500 |
| | 10 | Хар чавга | кг | 400 |
| | 11 | Хатаасан жимс | кг | 400 |
| | 12 | Жүрж | кг | 300 |
| | | | | |
| 5 | | Хүнсний ногоо | | |
| | 1 | Төмс | кг | 6000 |
| | 2 | Лууван | кг | 3000 |
| | 3 | Манжин | кг | 3000 |
| | 4 | Байцай | кг | 3000 |
| | 5 | Лууван/цагаан/ | кг | 600 |
| | 6 | Байцай/ягаан/ | кг | 600 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 7 | Хүрэн манжин | кг | 500 |
| | 8 | Улаан лооль | кг | 500 |
| | 9 | Шинэ өргөст хэмх | кг | 500 |
| | 10 | Сонгино | кг | 400 |
| | 11 | Сармис/монгол/ | кг | 150 |
| | 12 | Брокли | кг | 300 |
| | 13 | Амтат чинжүү | кг | 300 |
| | 14 | Цагаан цэцэгт байцай | кг | 300 |
| | 15 | Ногоон сонгино | ш | 300 |
| | | | | |
| | | Бүх төрлийн будаа | | |
| | 1 | Цагаан будаа | кг | 6000 |
| | 2 | Бор будаа | кг | 1500 |
| | 3 | Шар будаа | кг | 1000 |
| | 4 | Булгури будаа | кг | 1000 |
| | 5 | Хөц будаа | кг | 1000 |
| 6 | 6 | Хүүхдийн будаа | кг | 1000 |
| | | | | |
| Бусад | | | | |
| 7 | 1 | Ургамлын тос | ш | 600 |
| | 2 | Элсэн чихэр | кг | 600 |
| | 3 | Хатуу сахар | ш | 600 |
| | 4 | Далайн байцай | ш | 350 |
| | 5 | Шөлний байцай | ш | 349 |
| | 6 | Лаврын навч | ш | 199 |
| | 7 | Үзэм | кг | 350 |
| | 8 | варень | ш | 320 |
| | 9 | масло | кг | 110 |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| 1. Шалгах болон турших<br>(ГЕН – 1) | 1.1. Увс аймаг Тэс сумын ЕБ-ын нэгдүгээр сургуулиас томилсон ДХШ-ийн нэгжийн ажлын хэсэг шалгаруулсан оролцогчийн нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээг хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт<br>(ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) Санхүүжилт хүссэн албан тоот;<br>3) Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлсэн гүйцэтгэлийг төслийн менежерээр баталгаажуулна;<br>4) Нийлүүлж байгаа барааны шинжилгээний дүгнэлт ;<br>5) Хүлээн авсан ажлын хэсгийн акт<br>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| 3.Баталгаат засвар<br>(ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлагагүй. |
| 4. Төлбөр<br>(ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br>Гүйцэтгэлээр барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. |
| 5.Алданги оногдуулах<br>(ГЕН - 9) | 9.1. Алданги оногдуулах хувь: Гэрээний үнийн дүнгийн 0,5 хувь байна.<br>Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй. |

2

. Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. **ГЭРЭЭНИЙ МАЯГТ**[3] **БАТЛАВ.**

| **ЗАХИАЛАГЧ** | **НИЙЛҮҮЛЭГЧ** |
|---|---|
| *ТЭС СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ* | *"Аж ахуйн нэгж "* |
| ...................... | ...................... |

***Увс аймгийн Тэс сумын ЕБ-ын сургуулийн Дотуур байрны хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ.***

Дугаар №

Тэс сум

Нэг талаас **.......................** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас **.......................** (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож .... оны .. сарын ..-ны өдөр энэхүү (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь ***[хүнсний бүтээгдэхүүн]***-г (цаашид "бараа" гэх) ***[.............]*** (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь тендерт ялсан дээрх нэр төрлийн барааг 2025 оны .. дүгээр сарын ...-ноос 2025 оны ... дугаар сарын .. -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
   - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   - Бусад шаардлагатай баримт бичиг[1];
   - Үнийн санал;
   - Гэрээний тусгай нөхцөл;
   - Гэрээний ерөнхий нөхцөл;

---

[1] .Хоѐр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь; Санхүүжилтийн хуваарь.

_ [3].Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

| **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** | **НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** |
|---|---|
| /Сургуулийн захирал/ | /................../ |
| *[Гарын үсэг]*______________________ | *[Гарын үсэг]*_________________________ |

Утасны дугаар:

НЯГТЛАН БОДОГЧ:.....................

Утасны дугаар